

Өвөрхангай аймаг дахь БОЭТ хэвтүүлэн эмчлэх нийтлэг журам




ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЖУРАМ

Хувилбарын дугаар: 01

Хүчин төгөлдөр болсон огноо: 2022-12-28

Баримт бичгийн дугаар

Баримт бичгийг хариуцах нэгж			
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл:	Дотоод	Баримт бичгийн түвшин	2
		Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан:	ЭЭДЗ ЦСТөвийн эрхлэгч	Д.Болормаа Н.Долгосүрэн	<i>[Handwritten signatures]</i>
Самал өгсөн:	Зөвлөх багийн гишүүд Сувилахуйн менежер	Г.Бямбасүрэн Л.Алтантөгс Д.Энх-Амгалан Д.Тогтохдулам Б.Алтангана Б.Болортуяа	<i>[Handwritten signatures]</i>
Хянаж батласан:		БОЭТ-ийн захирал	<i>[Handwritten signature]</i> 

Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлтийг батласан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсонг товч тайлбарлана)
1			Баримт бичгийн анхны хувилбар

АГУУЛГА

1. **ЗОРИЛГО /5/**
2. **ХАМРАХ ХҮРЭЭ /5/**
3. **НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД /5-7/**
 - 3.1 Нэр томьёо
 - 3.2 Товчилсон үг
 - 3.3 Иш татсан баримт бичгүүд
4. **ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЭРХ МЭДЛИЙН МАТРИЦ /8- 9/**
5. **ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗАРЧИМ /9/**
6. **ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТАСАГ НЭГЖИД АЖИЛЛАЖ БУЙ ЭМЧ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА /9/**
 - 6.1 Зөвлөх эмчийн үүрэг хариуцлага /9/
 - 6.2 Тасгийн эрхлэгч эмчийн үүрэг хариуцлага/9-10/
 - 6.3 Эмчлэгч эмчийн үүрэг хариуцлага /10/
 - 6.4 Жижүүр эмчийн үүрэг хариуцлага /11/
 - 6.5 Ахлах сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага /11-12/
 - 6.6 Ээлжийн сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага /12
 - 6.7 Туслах сувилагчийн үүрэг, хариуцлага /12/
 - 6.8 Үйлчлэгчийн үүрэг, хариуцлага /13/
7. **ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ЗААЛТ- Хавсралт1**
8. **ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТАСАГ НЭГЖИЙН ЭМНЭЛЗҮЙН НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА /13-27 /**
 - 8.1 Эмчлүүлэгчийг хэвтүүлэх /13-15/
 - 8.2 Эмчлүүлэгчийг тасагт хүлээн авах
 - 8.3 Эмчлүүлэгч ба түүний асран хамгаалагч, гэр бүлд мэдээлэл, зөвөлгөө өгөх./16/
 - 8.4 Эмчлүүлэгчид эмчилгээ хийх /16/
 - 8.5 Тасгийн ээлж хүлээлцэх/16-17/
 - 8.6 Эмч нарын тойрон үзлэг хийх /17/
 - 8.7 Тасгийн ЭТҮХХ-аас сэргийлэх үйл ажиллагаа /17-21/
 - 8.8 Жижүүрийн ахлах эмчийн үйл ажиллагаа /21-22 /
 - 8.9 Жижүүр эмчийн үйл ажиллагаа /22-23 /
 - Хэвтүүлэн эмчлэх тасаг нэгжийн жижүүр эмчийн үйл ажиллагаа
 - Оргүй хэсгийн жижүүр эмч нарын үйл ажиллагаа
 - Эрэмбэлэн ангилалт яаралтай тусламжийн эмчийн үйл ажиллагаа
 - 8.10 Зөвлөх эмчийн үзлэг, зөвөлгөө /23-24/
 - 8.11 Эмч нарын хамтарсан үзлэг, зөвөлгөөн /24/
 - 8.12 Амилуулах, лавшруулсан тусламж үзүүлэх / code blue баг идэвхижүүлэх//24/
 - 8.13 Цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэх хийх тухай/24/
 - 8.14 Эмчлүүлэгчийг бусад тасаг, эмнэлэгт шилжүүлэх /25-26/
 - 8.15 Эмчлүүлэгчийг эмнэлгээс гаргах /26-27
 - 8.16 Нас баралтын тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ/27-28/
- ЕС. **ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИД, САХИУР, АСРАН ХАМГААЛАГЧИЙН БАРИМТЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ -/28-29/**
- АРВАН. ХАРИУЦЛАГА /29/**
- АРВАН НЭГ ХАВСРАЛТ /30/**

НЭГ. ЗОРИЛГО

1.1 Хэвтэн эмчлүүлэгчдэд аюулгүй чанартай тусламжийг тэгш хүртээмжтэй үзүүлэх

1.2 Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үзүүлэгч эмч эмнэлгийн мэргэжилтний харилцааг зохицуулах, үүрэг хариуцлага, сахилга дэг журам, тасаг нэгжийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахад оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ :

БОЭТөвийн нийт эмч эмнэлгийн мэргэжилтэн, эмчлүүлэгч түүний асран хамгаалагч, сахиур дагаж мөрдөнө.

ГУРАВ. НЭР ТОМЪЁО, ТОВЧИЛСОН ҮГС, ИШ ТАТСАН БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

3.1 НЭР ТОМЪЁО:

- Өвчний түүх :Эмнэлэгт хэвтэн үйлчлүүлэгчдэд хийгдэж буй оношилгоо, эмчилгээний явц, үр дүнг тусгасан БОЭТөвийн нууцийн зэрэгт хамаарах хуулийн, сургалт эрдэм шинжилгээний баримт бичиг

- Хамтарсан үзлэг, зөвөлгөөн : Нэг мэргэжлийн болон бусад нарийн мэргэжлийн нэгээс дээш эмч нар оролцон тухайлсан нэг эмчлүүлэгчийн биеийн байдал,эмчилгээ оношилгооны асуудлаар хэлэлцэн дүгнэлт шийдвэр гаргахыг

- Тойрон үзлэг: Тасгийн нийт эмч, резиденс эмч, сувлахуйн мэргэжилтнүүд тасгийн бүх эмчлүүлэгчдийн биеийн байдал, шинжилгээ оношилгоо, эмчилгээний байдалтай богино хугацаанд танилцан шаардлагатай санал дүгнэлт гаргахыг

- Сувилахуйн зөвөлгөөн: Хоёр ба түүнээс дээш сувилахуйн мэргэжилтнүүд эмчлүүлэгчийн сувилгаа асаргааны асуудлаар хэлэлцэн дүгнэлт гаргахыг

- Тусгаарлах (Isolation): Халдварт өвчний сэжигтэй, батлагдсан эмчлүүлэгчийг тусгай өрөөнд бусад үйлчлүүлэгчээс тусгаарлан байршуулах үйл явц

- Тусгаарлах өрөө (Isolation room): Халдвартай эмчлүүлэгчийг байрлуулах өрөө, палат

- Тэмдэглэгээ хийх -Flagging: Эрүүл мэндийн байгууллагаарүйлчлүүлэгчийн өвчний түүх, тусгаарлах өрөө, хэсэгт эмэнд тэсвэржсэн бичилбиетний халдвар/колонизаци-тай, эсвэл сэжигтэй гэсэн тэмдэглэгээ хийснээр эрүүл мэндийн байгууллагын ажилтанд сэрэмжлүүлэх дохио өгөх зорилготой үйл явц(Жишээ нь: B, C,).

- Өндөр хяналтат өрөө: Эрчимт эмчилгээний стандартад ойртуулан тоногдсон биеийн байдал хүнд хүндэвтэр өвчтнийг хэвтүүлэн эмчлэх өрөөг

- Өндөр хяналтат эмчлүүлэгч : Биеийн байдал хүнд хүндэвтэр өвчтнийг

- Телемедицины зөвөлгөө: Дээд шатны мэргэжилтнээс цахимаар зөвлөгөөн авахыг

- Шилжүүлэх: БОЭТөвийн тасаг хооронд болон эмнэлэг хооронд өвчтөнг шилжүүлэх

- Магадлагаа гаргах: Хүн өвчлөх, осол, гэмтэлд өртөх, нас барах, төрөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувилуулах, хөл хоригдох, өвчтөн асрах гэм мэтэд нотолгоо гаргах

- Эмгэг судлалын шинжилгээ: эмнэлэгт тусламж үйлчилгээ авах явцад

нас барсан эмчлүүлэгчид шинжилгээ хийж нас барсан шалтгааныг тогтоох

- Эмнэлэгээс гаргах: Эмчилгээг дуусган гэрт гарах
- “Code Blue”- Эмнэлгийн бүсэд өвчтөний амьсгал, зүрх судасны үйл ажиллагаа зогссон үед яаралтай үйлдэгдэх дохиоллын систем
- Анхны хариуцагч - Амьсгал зүрх судас зогссон, ухаангүй байдлыг анх мэдсэн ажилтан, иргэн
- ЭСҮ- Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ
- БОЭТ- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- ЭЭДЗ-Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
- ЭБЭК- Эх барих эмэгтэйчүүдийн клиник
- ХСХ- Халдварын сэргийлэлт хяналт
- ЭТҮХХ- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар
- ААЗ- Аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- ЭЭХ- Эрчим эмчилгээний хуудас
- СЭМТ-Сумын эрүүл мэндийн төв
- ӨЭМТ-Өрхийн эрүүл мэндийн төв
- ХЧА- Хөдөлмөрийн чадвар алдалт
- ШСДУ- Шингэн сэлбэх давсны уусмал

3.2 Холбогдолтой буюу иш татсан баримтжуулсан мэдээлэл

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламжийн тухай хууль
- ISO 9001:2015 ЧУТ-ны стандарт
- Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5095:2017 стандарт
- Оношлогоо эмчилгээ түгээмэл үйлдлүүд MNS 4621:2008
- ЭМС-ын 2019 оны А/611 тушаал
- ЭМС-ын 2019 оны А/537,538,539 тушаал
- ЭМСын 2018 оны А/505 “Хог хаягдлын менежмент”
- ЭМС-ын2018 оны А/485 “Жагсаалт журам батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тушаал
- ЭМС-ын 2017 оны А/55 “Эмгэг судлалын шинжилгээ хийх журмыг шинэчлэн батлах тухай”
- ЭМС-ын 2021 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн А/813 “Журам батлах тухай”
- БОЭТөвийн захирлын “Цусны салбар төвийн үйл ажиллагаа” 2021 оны 3 дугаар сарын 4-ний А/22 тоот тушаалын 9 дүгээр зүйл “цус цусан бүтээгдэхүүн захиалах олгох сэлбэх үйл ажиллагаа”-ны журам –хувилбар I
- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах нийтлэг журам I дахь хувилбар
- Цахим түүх бичих журам I дэх хувилбар
- “CODE BLUE”-амьлуулах лавшруулсан тусламж үзүүлэх журам - I дахь хувилбар

ДӨРӨВ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА (RACI матриц)

Хүснэгт1- Процессын үүрэг хариуцлагын матриц

Процесс	Тасгийн нэрхлэг ч	Зөвлөх эмч	Эмчлэгч эмч	САЗ	Сувилагч	Туслах сувил агч	ЧАБ А	ЭЭ ДЗ
1.Эмчлүүлэгчийг тасаг хүлээн авах, үнэлгээ өгөх	ACI	IC	RA	RA	RC	RC	I	I
2.Цахим түүх нээх	I	IC	RA	RA	RAC		I	I
3.Эмчлүүлэгчийн заагдсан эмчилгээг хийх			RA	RAC	RAC			
4.Шаардлагатай шинжилгээ бүрдүүлнэ. /шинжилгээ авах сорьц өгөх хариу авах /	I	I	RA	RA	RC	C	I	I
5.Тасгийн ээлж хүлээцэх /сувилахуйн үнэлгээ тусламж/	RA	RA	RC	RAC	RAC	iC	I	
6. Ажилбар хийх	C	C	RA	IC	RAC	C	I	I
7.Эмчлүүлэгч түүний гэр бүлд мэдээлэл өгөх	A	A	RA					A
8.Амилуулах, лавшруулсан тусламж үзүүлэх / CODE BLUE баг идэвхижүүлэх/	IA	IA	RA	CA	RAC	C	IC	IC
9. Өвчний түүхэнд тэмдэглэл баримтжуулалт хийх	IC	IC	RA	RA	RA			

Өвөрхангай аймаг дахь БОЭТ хэвтүүлэн эмчлэх нийтлэг журам

10.Эмч нарын тойрон үзлэг хийх	IC	IC	RA	IC	IC	IC	C	C
11.Эмч нарын хамтарсан үзлэг зөвөлгөөн хийх	IC	IC	RA	RA	RA	C	IC	A
12. Лавалгаа шатны тусламж авах /зөвөлгөө авах, дуудлага дуудах шилжүүлэлт шийдэх/	RAC	I	RA				C	CA
13. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх			RA	RA	RAC		IC	IC
14. Холбогдох дүгнэлт, магадалгааг гаргах	A	C	RA					A
15. Зөвшөөрөл авах баталгаажуулах	I	I	RA	RA	RA	C	I	I
16.Эмгэг судлалын шинжилгээ хийх	RA	I	RA	C	C	C	A	A

(R- гүйцэтгэх, A- хариуцах, C- хамтран ажиллах, I-мэдээлэлтэй байх)

ТАВ. ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗАРЧИМ :

5.1 Орчин үеийн анагаах ухааны нотолгоонд суурилсан дэвшилтэт технологийг тусламж үйлчилгээндээ байнга нэвтрүүлнэ.

5.2 Эмчлүүлэгч, түүний гэр бүлийн оролцоог дэмжсэн тусламж үзүүлж тэдний аюулгүй байдал, эрх ашиг, зан заншлыг хүндэтгэж, нууцыг хадгална.

5.4 Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган хүндрэлээс урьдчилан сэргийлж ажиллана.

5.5 Эмчлүүлэгчид хүмүүнлэг, энэрэнгүй эрчимт эмчилгээ тусламжийг тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

ЗУРГАА. ЭМЧ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА:

6.1 Зөвлөх эмчийн үүрэг хариуцлага

- Эмнэл зүйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн үнэлгээ, шүүмж дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх (ховор тохиолдол, шинэ технологи, ноцтой хүндрэл, нас баралт, давтан мэс засал, гомдол)

- Эмчлэгдэж буй биеийн байдал онц хүнд эмчлүүлэгчид эмчлэгч эмчийн хүсэлтээр үзлэг хийж, эмчилгээ, оношилгоо асуудлыг шийдвэрлэхэд зөвлөн туслаж бүртгэл үүсгэнэ.
- Тасгийн эмч нарын тойрон болон хамтарсан үзлэг, зөвөлгөөнд оролцон, удирдана.
- Эмч нарын хамтарсан болон тойрон үзлэгийн дүгнэлт шийдвэрийг ар гэрийнхэнд танилцуулах, зөвөлгөө мэдээлэл өгнө.
- Өөрийн эзэмшсэн нарийн мэргэжлийн чиглэлээр 2-5 эмчлүүлэгчийн эмчлэгч эмчээр ажиллах
 - Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.2 Тасгийн эрхлэгч эмчийн үүрэг хариуцлага

- Тасгийн үйл ажиллагааг төлөвлөн удирдан, зохион байгуулж үр дүнг тайлагнана.
- Тасгийн чанарын багийг удирдан зохион байгуулж чанарын үзүүлэлтийг тогтмол хянаж сайжруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Тасгийн эмч мэргэжилтний ажил үүрэг, жижүүрийн хуваарийг гаргаж хэрэгжилтэнд хяналт тавиж ажиллах ба сар бүр ажилтны гүйцэтгэлийг дүгнэнэ.
- Тасгийн эрсдлийн үнэлгээг жил тутамд үнэлж эрсдлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг тооцно.
- Эмч, сувилагч нарт ААЗааварчилгааг өглөө бүр өгч баталгаажуулна.
- Тасгийн тойрон үзлэгийг тасгийн зөвлөх эмч, эмч, сувилагч нарын хамт өдөр бүр хийнэ.
- Шаардлагатай тохиолдолд эмчлэгч эмчийн хүсэлтээр үйлчлүүлэгчийг үзэж эмчилгээ оношлогоонд зөвлөгөө өгнө.
- Тасгийн хурлыг зохион байгуулж шаардлагатай асуудлыг тухай бүр нь шийдвэрлэнэ.
- Эмчлүүлэгчийн оношилгоо эмчилгээ сувилгааны стандарт, ХСХ дэглэм мөрдөлт, өвчний түүхийн чанар төлбөрийн хяналтыг тогтмол тавьж, тасгийн эмч мэргэжилтэнд заавар зөвлөгөө өгнө.
- Эмчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд эмчилгээ үйлчилгээтэй холбоотой мэдээллийг өгч, тэдний санал хүсэлт гомдолыг хүлээн авч тасгийн хүрээнд шийдвэрлэх боломжтой бо шуурхай шийдвэрлэнэ.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.3 Эмчлэгч эмчийн үүрэг хариуцлага:

- Эмчлүүлэгчийн биед бүрэн үзлэг хийж, ОЭСтандарт удирдамжийг чанд баримтлан оношилж, эмчлэн цахим өвчний түүхийг хөтлөж баримтжуулна.
- Шаардлагатай оношилгоо шинжилгээ, эмчилгээний нэмэлт ажилбарыг төлөвлөж гүйцэтгэнэ.
- Эмч нарын хамтарсан үзлэгийн бэлтгэлийг хангаж холбогдох шинжилгээ бүрдүүлнэ.
- Өндөр хяналттай эмчлүүлэгчид ЭСҮ хийж журмын дагуу хянан

баталгаажуулж шуурхай арга хэмжээ авч хүндрэлээс сэргийлж ажиллана.

- Эмчлүүлэгчийн эмчилгээг хянан сувилагч, туслах сувилагчид зааварчилгаа өгч удирдан ажиллана.

- Халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан, сувилагч, туслах сувилагч нарт хяналт тавьж ажиллана.

- Эмчлүүлэгчийн ЭТҮХХ шинж тэмдгийг тандах, урьдчилан сэргийлэх, ба Халдварт өвчин илэрсэн тохиолдолд шаардлагатай хариу арга хэмжээг шуурхай авна.

- Жижүүр хуваарийн дагуу ээлжээр ажиллана.
- Эмчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд оношилгоо эмчилгээ үйлчилгээтэй холбоотой мэдээлэл зөвөлгөө өгнө.
- Эмчлүүлэгчийг жижүүр эмчтэй биечлэн хүлээлцэнэ.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага
-

6.4 Ахлах сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага:

- Сувилагч нарын ажил үүрэг, амралтын хуваарь, гарган удирдлагаар хангана.
- Анхан шатны бүртгэлийн маягт, цахим сувилахуйн түүхийн хөтлөлтөнд

хяналт тавих

- Сувилахуйн тусламж үйлчилгээг стандартын дагуу гүйцэтгэхэд хяналт тавьж

сувилагчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж арга зүйн зөвлөмж өгнө.

- Тасгийн орчны болон сувилахуйн эрсдлийн үнэлгээг жил тутамд багаар хийж эрсдлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг тооцно.

- Сувилагч нарт ААЗааварчилгааг өглөө бүр өгч баталгаажуулна.

- Эмчлүүлэгчийн биеийн байдал, хийгдэж байгаа сувилахуйн тусламжийн үр дүнг үнэлж эмчлүүлэгчийн онцлогт тохирсон сувилахуйн төлөвлөгөөг ээлжийн сувилагчтай хамтран гаргаж хэрэгжилтэнд хяналт тавина.

- Эм, эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн нөөц, аюулгүй бэлэн байдал ашиглалтанд хяналт тавих

- Эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол цуглуулан дүгнэж ажиллах

- Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хянаж, төлөвлөсний дагуу буюу шаардлагатай үед засвар үйлчилгээ хийлгэх

- Сувилагч нарын ур чадварыг сайжруулах, шинэ ажилтанг сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулна.

- Тасгийн ХСХ-ын ажилтны үүргийг гүйцэтгэж эмчлүүлэгчийн өрөөнд тусгай тэмдэглэгээ байршуулна.

- Эмчлүүлэгчийн болон сахиурын журмыг таниулах баталгаажуулах

- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.5 Ээлжийн сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага:

- Эмчлүүлэгчийн сувилахуйн үнэлгээг хийж сувилахуйн төлөвлөгөөг хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллах

- Эмчлүүлэгчид заагдсан сувилахуйн тусламж, үйлчилгээ, хяналтыг

холбогдох журам стандартын дагуу чанартай шуурхай аюулгүй үзүүлнэ.

- Анхан шатны бичиг баримт болон цахим сувилгааны түүхийг стандартын дагуу хөтлөнө.
- Биед байрлуулсан гуурс, шархны байдлыг тандах, халдварын эрсдлийг илрүүлэх мэдээлэх
 - Эмчийн бичсэн эмчилгээ, гаргацгүй, ойлгомжгүй бол эмчээс заавал тодруулна.
 - Эмчлүүлэгчийн биеийн байдалд зовуурь илэрсэн, амин үзүүлэлт, шинжилгээний үзүүлтэнд хойшлуулашгүй байдал илэрсэн үед эмчлэгч болон жижүүрийн эмчид мэдэгдэн эмчид мэдэгдсэн цагийг цахим түүхэнд тэмдэглэнэ.
 - Тасгийн ээлжийн сувилагч болон туслах сувилагч нь үйлчлүүлэгчийн асаргаа сувилгааг гардан хийнэ./ Амны хөндий, толгой, хагас болон бүтэн биеийн угаалга хийх г.м. Эмчлүүлэгчийн уусан ба ялгаруулсан шингэний хэмжээг сувилагч өөрөө харж тэмдэглэнэ.Үйлчлүүлэгчийг бусад хүндрэлээс сэргийлж (нуралт, цооролт үүсэх г.м) ажиллана.
 - Эмчлүүлэгч болон түүний ар гэрийхэн, асран хамаалагч нартай эелдэг найрсаг харилцана.
 - Тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл ороох боох материалын захилгыг хийж, орлого зарлага бэлэн байдалд хяналт тавиж ажиллана.
 - Эмнэлгийн тусгай хог хаягдлыг стандартын дагуу ангилан, устгаж баталгаажуулна.
 - Эмчлүүлэгчийг биечлэн хүлээлцэнэ.
 - Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.6 Туслах сувилагчийн үүрэг, хариуцлага:

- Эмчлүүлэгчийн асаргаа сувилгааг гардан хийнэ./ цагаан хэрсэл солих, хооллох, агаар салхинд гаргах, бие заслуулах, хувцас хэрэгсэл солих, амны хөндий, толгой, хагас болон бүтэн биеийн угаалга хийх гэх мэт /
 - Эмчлүүлэгчийг бусад хүндрэлээс сэргийлж (нуралт, цооролт үүсэх г.м) ажиллана.
 - Эмчлүүлэгчийг эмнэлгээс гарсны дараа сул ор, тумбочик зэргийг халдваргүйжүүлэх ба орыг засаж эмчлүүлэгчийг хүлээн авахад бэлдэнэ.
 - Эмнэлгийн тусгай хог хаягдлыг стандартын дагуу ангилан, устгаж баталгаажуулна.
 - Эмчлүүлэгчид хэрэглэсэн багажийг ариутгалд хүлээлгэн өгөх хүлээн авах
 - Эмчлүүлэгчийн сорьц, цагаан хэрэгсэл зэрэг туслах эд материал, хэрэгсэлийг тасаг хооронд зөөвөрлөн хүргэх
 - Эм эмнэлгийн хэрэгсэлийг захиалгын дагуу эмийн сангаас хүлээн авч тасагт зөөвөрлөхөд эм зүйч сувилагчтай хамтран ажиллах
 - Эмчлүүлэгчийг тасаг хооронд шилжүүлэх, багажийн шинжилгээ, гадуур эмчилгээ оношилгоонд эмчлүүлэгчийг зөөхөд бие даан болон сувилагч эмчтэй хамтран ажиллана.
 - Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээг өдөр тутам хийнэ.
 - Эргэлтийн хуваарийг мөрдүүлж хяналт тавина.
 - Эмчлүүлэгч болон түүний ар гэрийхэн, асран хамаалагч нартай эелдэг

найрсаг харилцана.

- Бусад хууль хурамд заагдсан үүрэг хариуцлага.

6.7 Жижүүр эмчийн үүрэг хариуцлага:

- Эмчлүүлэгчийг эмчлэгч эмчээс биечлэн хүлээн авна
- Эмчлүүлэгчийг бүрэн үзлэг хийж өвчтний түүхэнд тэмдэглэн баримтжуулна.
- Шаардлагатай шинжилгээ, нэмэлт ажилбарыг төлөвлөж гүйцэтгэнэ.
- Жижүүр эмч нарын хамтарсан үзлэгийн бэлтгэлийг хангаж холбогдох шинжилгээ бүрдүүлнэ.
- Эмчлүүлэгчийн эмчилгээнд өөрчлөлт оруулах шаардлагатай бол тасгийн эрхлэгч эмч, эмчлэгч эмчтэй зөвшилцөн шийднэ.
- Эмчлүүлэгчийг цаг тутамд амьсгал, цус эргэлтийн байдлыг үнэлж хянана.
- Эмчлүүлэгчийн эмчилгээг хянан сувилагчид зааварчилгаа өгч удирдан ажиллана
- Халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан, сувилагч, туслах сувилагч нарт хяналт тавьж ажиллана.
- Эмчлүүлэгчид ЭТҮХХ шинж тэмдгийг тандан шаардлагатай хариу арга хэмжээ авна.
- Жижүүрийн хугацаанд эмчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд эмчилгээ үйлчилгээтэй холбоотой мэдээллийг өгнө.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.8 Үйлчлэгчийн үүрэг, хариуцлага:

- Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537-ийн 6 дугаар хавсралт, Захиралын 2014 оны А127 тушаалыг чанд баримтлан цэвэрлэгээ үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэнэ.
- Өөрийгөө хамгаалах болон бусдад халдвар тараахгүйн үүднээс гар угаах стандартыг мөрдөж ажиллана.
- Тасгийн халдварын эсрэг дэглэмийг сахин ажиллана.
- Халдварт өвчний голомтонд ажиллах үед халвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллаж өөрийгөө болон үйлчлүүлэгчийг халдварт өртөхөөс хамгаална.
- Орчны аливаа эрсдлийг анхаарч мэдээлэх, засаж сайжруулах санал ирүүлнэ.
- Энгийн хог хаягдлыг журмын дагуу устгана.
- Үйлчлүүлэгч болон түүний ар гэрийнхэн, асран хамаалагч нартай эелдэг найрсаг харилцана.
- Бусад үйл ажиллагаа

ДОЛОО. ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ЗААЛТ

- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай жил бүр шинэчлэн байгуулсан

оношийн бүлгээр тасаг клиникт эмчлүүлэгчийг хүлээн авна. /хавсралт -1/

НАЙМ. ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ КЛИНИК ТАСГИЙН ЭМНЭЛЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1 ЭМЧЛҮҮЛЭГЧИЙГ ХЭВТҮҮЛЭХ

8.1.1 Амбулаторид үзлэг хийсэн эмч шаардлагатай өвчтөнийг хэвтэх дугаарт авч, өвчтний биеийн байдлыг хүндийн зэргээр эрэмбэлэн EHealth программд хэвтүүлэх захиалга үүсгэн бүртгэнэ.

8.1.2 Эмч өвчтний биеийн байдлыг эрэмбэлж яаралтай, хойшлуулшгүй, төлөвлөгөөт гэсэн төлөвт бүртгэж хэвтүүлэх бүртгэлд бүртгэнэ. Эмнэлэгт яаралтай хэвтүүлэх заалттай хүнд өвчтөнийг ЭЭДЗ-д мэдэгдэж, яаралтай журмаар үйлчлүүлэгчийн нэгэн адил дараалал харгалзахгүй хэвтүүлнэ. Хойшлуулшгүй эрэмбэд орсон үйлчлүүлэгчийг ажлын 1-2 хоногт, төлөвлөгөөт эрэмбийн үйлчлүүлэгчийн эмнэлэгт хэвтэлтийг ажлын 2-5 хоногт багтаан тухайн мэргэжлийн тасгийн эрхлэгч эмч эмчлэгч эмчийг зааж цохолт хийн шийдвэрлэнэ.

8.1.3 Бусад эмнэлгээс хэвтэх хүнд өвчтний орны зохицуулалтыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал шийдвэрлэнэ.

8.1.4 Эмч өвчтнийг эмнэлэгт хэвтүүлэх шийдвэр, тусламж үйлчилгээ, түүний үр дүнгийн талаар өвчтөн ба түүний ар гэрийнхэнд тодорхой мэдээлэл өгсөн байна

8.1.5 ЯТТ-ийн ажиглалт, хяналтын хэсэгт хянагдсан өвчтөнүүд назологийн дагуу тасагт дараалал харгалзахгүй хэвтэнэ.

8.1.6 Эмнэлзүйн сургагч багшийн удирдлага дор суралцаж буй ерөнхий мэргэжлийн резидент, өрх сумын эрүүл мэндийн төвөөс богино хугацаанд дагалдан суралцаж байгаа эмч нар хэвтүүлэн эмчлэх захиалга өгөх эрхгүй.

8.1.7 Ахлах сувилагч нар тухайн өдрийн 14:30-15:00 цагийн хооронд сул орны мэдээг ЭЭДЗахирал, тасгийн эрхлэгчид өгнө. Эмнэлгийн орыг давхардуулахгүйгээр дугаарлан тэмдэглэсэн байна.

8.1.8 Тасгийн эрхлэгч орны дараалалд орсон хуваарийн дагуу хэвтэх шаардлагатай үйлчлүүлэгч рүү утсаар холбогдон маргааш өглөөний 09.30-11:30 цагийн хооронд эмнэлэгт хэвтэхээр ирэхийг мэдэгдэнэ.

8.1.9 Төрөлжсөн мэргэжлийн дараах тасгууд шаардлагатай үед сул орон дээр бусад назологийн эмчлүүлэгчийг зохицуулан хүлээн авч хэвтүүлж болох ба эмч нар аль ч тасаг клиникт хэвтэж байгаагаас үл хамааран эмчлүүлэгчийг өөрийн мэргэжлийн чиглэлээр үзэж эмчлэх ба тухайн эмчлүүлэгчийн хэвтэн эмчлүүлж байгаа тасгийн сувилахуйн багтай хамтран ажиллана.

Үүнд : Мэс заслын чиглэлийн тусламж шаардлагатай эмчлүүлэгчийг мэс засал, гэмтэл, хавдар, ЧХХНЭНМЗТасагт

Доторын чиглэлийн тусламж шаардлагатай эмчлүүлэгчийг Дотор, мэдрэл сэтгэц, Уламжлалт сэргээн засах, хөнгөвчлөх тасгуудад

8.1.10 Эмнэлэгт хэвтэхээр ирсэн үйлчлүүлэгчийг цахим бүртгэлийн хэвтүүлэлт хариуцсан мэргэжилтэн хүлээн авч, шаардлагатай урьдчилгаа, хамтын болон хагалгааны төлбөр зэргийг бүрэн төлүүлж, өвчний түүхийг нээн таних бугуйвчийн мэдээллийг бичиж өгнө.

8.1.11 Үйлчлүүлэгч хэвтэхээр ирэхдээ цахим иргэний үнэмлэх, 13 маягт, эмчлүүлэгчийн карт, шинжилгээ, эмнэлгийн хуудас авах бол бөглөгдсөн нийгмийн телевиз Даатгалын дэвтэр зэрэг бичиг баримтыг бүрдүүлэн авчирсан байна.

8.1.12 Үйлчлүүлэгч ор хөнжлийн даавуу, аяга халбага, биед чөлөөтэй, цайвар хувцас, шаахай, хувийн ариун цэврийн хэрэглэл зэргийг бэлтгэн авч ирнэ.

8.1.13 Тасагт орж хэвтэхдээ бичиг, баримт, үнэт эдлэл, овор ихтэй хувийн эд зүйл, цахилгаан хэрэгсэл авч хэвтэхийг хориглох бегеед зайлшгүй шаардлагатай бичиг

баримтыг ахлах сувилагчид хүлээлгэн өгч хадгалуулаад гарахдаа буцаан авна. Дээрх заалтыг зөрчин авч орсон үнэт эдлэл, бичиг баримт, цахилгаан хэрэгсэл алдагдсан тохиолдолд байгууллага хариуцлага хүлээхгүй болно.

8.1.14 Хөтөч сувилагч нар хэвтүүлэн эмчлүүлэх үйл ажиллагаатай холбоотой лавалгаа мэдээллийг үйлчлүүлэгчид өгөх ба өвчний түүх нээгдсэн эмчлүүлэгчдийг тасагт хүргэж өгнө.

8.1.15 Асран хамгаалагч, сахиур шаардлагатай тохиолдолд түүнд энгэрийн тэмдэг өгөх ба эмчлүүлэгчийг гарах үед буцаан авна.

8.1.16 Яаралтай тусламжаар ирсэн өвчтөн бүрт эрэмбэлэн ангилалт хийж, зохих шинжилгээнүүдийг бүрдүүлсэн байна.

8.1.17 ЯТТ-аас тухайн эмчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлэх шийдвэрийг холбогдох мэргэжлийн тасгийн эрхлэгч болон жижүүрийн эмч нар гаргах ба ЯТТ-ийн эмч программд бүртгэж, хэвтүүлэх захиалга илгээнэ.

8.1.18 Гамшиг,ослын үед эмнэлгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу ажиллаж орыг зохицуулна.

8.2 ЭМЧЛҮҮЛЭГЧИЙГ ТАСАГТ ХҮЛЭЭН АВАХ

8.2.1 Эмчлүүлэгчийн өвчний түүхийн мэдээлэл,бугуйвчийн мэдээллийг тулган ажлын цагаар ахлах сувилагч, жижүүрийн цагт жижүүр сувилагч хүлээн авна.

8.2.2 Эмчлүүлэгчийн овог, нэр, нас, хүйс онош, мэдээллийг тасгийн хэвтэгсэдийн бүртгэлд бүртгэх /Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/611 дүгээр тушаалын арваннэгдүгээр хавсралт Эрүүл мэндийн бүртгэлийн маягт СТ-13А / ба өндөр хяналттай эмчлүүлэгчийн мэдээллийг орны дэргэдэх самбарт, орны дугаарыг түүхэнд тэмдэглэнэ.

8.2.3 Илгээсэн эмчийн бичиг, эмчлүүлэгчийн карт, 13А тай бүрэн танилцаж эмчлүүлэгчийн биед бүтэн үзлэг хийж , тусламж үйлчилгээний заалтыг гаргаж өвчний цахим түүхийг журмын дагуу баримтжуулна

- Хоол
- Эмчилгээ
- Ажилбар
- Шинжилгээ төлөвлөнө.

8.2.4 Эмчлэгч болон жижүүрийн эмч арга хэмжээний төлөвлөгөөг сувилагчид тайлбарлаж, ойлгомжгүй зүйл байгаа эсэхийг нягтална.

8.2.5 Эмчлүүлэгчийн эмнэлэгээс гарах өдрийг эмчлэгч эмч товлон тэмдэглэгээг түүхэнд тэмдэглэх ба эмчилгээний дундаж хоног 7-10 хоног байна.

8.2.6 Ахлах сувилагч, сувилагч эмчлүүлэгчдэд тухайн тасгийн хэвтэн эмчлүүлэгсдийн болон сахиурын мөрдөх журмыг танилцуулж баталгаажуулан өрөөнд нь хүргэж өгнө.

8.2.7 8.3 ЭМЧЛҮҮЛЭГЧ БА ТҮҮНИЙ АСРАН ХАМГААЛАГЧ, ГЭР БҮЛД МЭДЭЭЛЭЛ, ЗӨВӨЛГӨӨ ӨГӨХ.

8.3.1 Мэдээллийн агуулгад өвчтний биеийн байдал, хийгдэж байгаа эмчилгээ оношилгооны үр дүн, урьдчилсан онош биед гарсан өөрчлөлт цаашидын хүлээгдэж байгаа хүндрэл эрсдэл, тавилан зэрэг мэдээллийг багтаах ба гэр бүлийн гишүүдийн асуултанд хариулна.

8.3.2. Эмчлүүлэгчийн биед ноцтой байдал үүссэн тохиолдол

-Амин эрхтний ноцтой хүндрэл үүсэх

-Их хэмжээний цус алдалт

-Харшил урвал

-Сэтгэл зүйн ноцтой хямрал гарсан тохиолдол бүрд, өндөр хяналтанд эмчлэгдэж байгаа ч биеийн байдал тогтвортой эмчлүүлэгчийн гэр бүлд өдөр бүр, ердийн хяналтанд биеийн байдал тогтвортой эмчлүүлэгчийн гэр бүлтэй эмчилгээний туршид хоёроос доошгүй удаа мэдээллийг зөвхөн эмч өгнө.

8.2.3 Эмчлүүлэгчийн ар гэрт мэдээлэл өгөхдөө эрүүл мэндийн сайдын 2019 оны 406 тоот тушаалыг чанд баримтална.

8.2.4 Хөтөч сувилагч нарт хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний зохион байгуулалтын талаарх нэмэлт мэдээллийг иргэнд утсаар өгөх боломжтой байна

8.4 ЭМЧЛҮҮЛЭГЧИД ЭМЧИЛГЭЭ ХИЙХ

8.4.1 Хэвтэн эмчлүүлэгчийн өвчний түүхийг эмч нар нээж, өдөр тутмын үзлэг дүгнэлт хийх ба оношилгоо, эмчилгээний төлөвлөгөөг гарган эмийн эмчилгээний захиалгыг 15 цагт бүрэн өгч дууссан байна.

Өвчний түүхэнд товчлол хийж бичихийг хориглоно.

8.4.2 Сувилагч бүх эмчлүүлэгчийн эмийн захиалгыг нэгтгэн тасгийн эрхлэгчээр хянуулан эмзүйн албанд илгээнэ.

8.4.3 Хэвтэн эмчлүүлэгчийн эмчилгээнд заагдсан хорт сэтгэц нөлөөт эм эрсдэлтэй эм, эмчилгээний нийцэл зэргийг хяналтыг клиник эм зүйч болон эм зүйн албаны дарга нар хийж түүврийг цохон баталгаажуулж тасаг хариуцсан эм зүйч нар эмийг савлан авч тасгуудын эмчлүүлэгчдэд түгээнэ.

8.4.4 Хэвтэн эмчлүүлэгчийн эмчилгээнд эмнэлэгт хэвтсэн өдрөөс эхлэн хийгдэх захиалгыг долоо хоногийн 1,3,5 өдрүүдэд үндсэн захиалга хийнэ. Эмчлүүлэгчийн биеийн байдалд тохируулан өдөр бүр нэмэлт захилга хийж болно.

8.5 ТАСГИЙН ЭЭЛЖ ХҮЛЭЭЛЦЭХ

8.5.1 Сувилагч нар өглөө 8:40-09:00, орой 16.30-17:00 хооронд эмчлүүлэгчийн өрөө бүрээр орж ээлж хүлээлцэх ба хүлээлцэх үедээ өвчтөнүүдийн биеийн байдал, эмчилгээ үйлчилгээ асаргаа сувилгааны онцлогийг хоорондоо мэдээлнэ. Мөн ЭЭХуудасны эмчилгээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хүлээлцэн, жижүүр хүлээлцэх бүртгэлд баримтжуулна. /хавсралт -2/

8.5.2 Эмч нар тасгийн нийт өвчтнүүдийн биеийн байдал, хяналт шинжилгээ эмчилгээнд анхаарах онцлох асуудлыг хамруулан ерөнхий мэдээлэл солилцох ба тасгийн **өндөр хяналтат** /биеийн байдал хүнд хүндэвтэр/эмчлүүлэгчийг хүлээлцэхэд эмч сувилагч нар дараах мэдээллийг багтаана

- 1) Эмчлүүлэгчийн ерөнхий мэдээлэл (нэр, хүйс)
- 2) Өвчний түүх, үндсэн болон дагалдах онош
- 3) Эмчлүүлэгчийн биеийн байдал:
 - ухаан санааны байдал, амин үзүүлэлтүүд, эмнэлзүйн шинж тэмдэг
 - Лабораторийн хэвийн бус үзүүлэлтүүд

- Биед орсон гарсан шингэний баланс
 - Урсгуурын төрөл, байдал, гарсан зүйлийн хэмжээ
 - Шарх боолтын байдал
 - Тусгай эмийн бодис (даралт бууруулах, бүлэгнэлтийн эсрэг, хавдрын эсрэг гэх мэт)
 - Шинжилгээ, ажилбарын бэлтгэл, үр дүн, төлөвлөлт
 - Эмчлүүлэгчид холбосон төхөөрөмж,
 - Бусад хэвийн бус байдлууд (дотор муухайрах, бөөлжих, өвдөлт, шархны өөрчлөлт гэх мэт)
- 4) Эмчлүүлэгчид гарч болох эрсдэл
- Гуурс, төхөөрөмжийн гаралтай халдвар
 - Унах эрсдэл
 - Дарагдлын шарх, холголтын эрсдэл
 - Халдвартай эмчлүүлэгчийг тусгаарлалт

8.5.3 Ажлын өдрийн өглөө бүр тасгийн эрхлэгч ахлах сувилагч нар жижүүрийн эмч сувилагч нартай хүлээлцэх ба тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх санал хүсэлт, алдаа дутагдлыг дотоод хяналтын тэмдэглэлд тэмдэглэн шийдвэрлэнэ.

8.5.4 Эмчлэгч эмч 17:00 цагаас өмнө эмчлүүлэгчийн онош, шинжилгээ, эмчилгээний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна .

8.6 ЭМЧ НАРЫН ТОЙРОН ҮЗЛЭГ ХИЙХ:

8.6.1 Хэвтүүлэн эмчлэх тасгууд өөрийн онцлогт тохируулан ажлын өдрүүдэд тасгийн бүх өвчтөнүүдийг долоо хоногт нэгээс доошгүй удаа тойрон үзлэгээр үзэж цаашдын онош эмчилгээний асуудлаар шаардлагатай санал шийдвэр гаргана.

8.6.2. Тойрон үзлэгийг тасгийн эрхлэгч, зөвлөх эмч нар удирдан тасгийн бүх эмч, резиденс, сувилагч мэргэжилтнүүд оролцоно.

8.6.3 Эмчлэгч эмч нар эмчлүүлэгчийн онош, эмчилгээ, шинжилгээний үзүүлэлт, биеийн байдлыг тойрон үзлэгт оролцож байгаа эмч, мэргэжилтэнд танилцуулан тойрон үзлэгийн дүгнэлт шийдвэрийг өвчний түүхэнд тэмдэглэл бичиж баримтжуулна.

8.6.4 Тойрон үзлэгийн бүртгэлийг тогтмол бүртгэнэ ./хавсралт-2/

8.7 ТАСГИЙН ЭТҮХХ-ААС СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.7.1 Эрүүл мэндийн бүх ажилтнууд ЭТҮХХалдвараас урьдчилан сэргийлэх дэглэмийг баримтлахын зэрэгцээ эмнэлгийн бусад үйлчлүүлэгчдэд олон эмэнд дасалтай нянгийн халдвар тархахаас чанд сэргийлнэ.

8.7.2 Гарыг халдваргүйжүүлэх аргыг эрүүл мэндийн бүх ажилтнууд дараах зааврыг мөрдөнө. Халдваргүйжүүлэх хугацаа 20-30 секундээс багагүй байна.

- Спиртэн суурьтай гар халдваргүйтгэлийн бодисийг бүх ажилтнууд зааврын дагуу хэрэглэнэ:

- Эмчлүүлэгчийн өрөөнд орохын өмнө болон орсны дараа (хаалга, хөшиг, орны орчим гэх мэт)
- Бээлий өмсөхийн өмнө
- Эмчлүүлэгчид хүрэхийн өмнө болон хүрсний дараа
- Эмчлүүлэгчийн орчин хүрэхийн өмнө болон хүрсний дараа
- Гараа савандаж угаах / Гар угаах хугацаа 1 минут/
- Цус, бусад биеийн шингэнд хүрэлцсэний дараа

- Гар бохирдсон үед
- Бээлий тайлсны дараа

8.7.3 Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөх тайлах

- Эмнэлгийн мэргэжилтэн нь ТҮ-ний явцад цацагдсан шүлс, цус, усны дуслаас халдварт өртөх эрсдлээс сэргийлж нүдний салст бүрхэвч, амьсгалын замын салст бүрхэвчийг хамгаалах зорилгоор хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг хэрэглэнэ.
 - Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг эмчилгээний бүсийн гадна байрлуулах бөгөөд дахин ашиглах зориулалттай хамгаалалтын нүдний шил, нүүрний хаалтыг үйлчлүүлэгч бүрийн дараа үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэнэ.
 - Нэг удаагийн хэрэглээнд зориулсан бээлий хэрэглэнэ. Бээлий хэрэглэхээс өмнө, бээлий тайлсны дараа, хэрэглэж байх явцад урагдах, цоорсон тохиолдолд, дараагийн үйлчлүүлэгчид үзлэг хийх хооронд гарын ариун цэврийг заавал сахина.
 - Удаан үргэлжлэх ажилбарын үед бээлийг 90 минутаас дээш хугацаагаар өмсөхгүй бөгөөд өмсөх шаардлагатай бол гарын ариун цэврийг сахисны дараа шинэ бээлий хэрэглэнэ.
 - Эмчилгээний үед цус, шүлс цацагдахаас сэргийлж хамар, ам, эрүүг бүрэн халхалсан амны хаалтыг хэрэглэх бөгөөд үйлчлүүлэгчийг үзэх бүрт сольж хэрэглэнэ.
 - Сүрьеэгийн микобактер зэрэг агаараар дамжих халдварын үед урьдчилан сэргийлэхийн тулд N95, N99 эсвэл N100 шүүлтүүртэй амны хаалт өмсөнө.
 - Нүүр амны эмчилгээний явцад шүдний хагархай, эмтэрхий, чулуу үсрэх зэргээс үйлчлүүлэгчийг хамгаалж нүдний шил болон нүүрний хэсгийг хамгаалах даавуу хэрэглэнэ.
 - Амны хөндийн тусламж, үйлчилгээний үед гар болон биеийн бусад хэсэг бохирдохоос сэргийлж урт ханцуй бүхий нэг удаагийн халадыг өмсөнө.
 - Нэг удаагийн халад, малгайг тусламж, үйлчилгээ үзүүлэхийн өмнө өмсөж, үйлчилгээ дууссаны дараа, харагдахуйц бохирдсон тохиолдолд аль болох хурдан солино.
 - Нэг удаагийн халадыг эмнэлзүйн бүсээс гадна хэрэглэхгүй, дүрэмт хувцсыг эмнэлгээс гадуур өмсөхийг хориглоно.
 - Эмнэлгийн гутал нь урдуураа битүү байх бөгөөд эмнэлгээс гадуур өмсөхийг хориглоно.
 - Рентген зураг авах, бохирлогдсон PSP-ийн хальс барих үедээ бээлий болон бусад хамгаалах хэрэгслийг өмсөнө.

8.7.4 Тасагт тусгаарлах

- Тасаг нь халдварын дамжих замд суурилсан халдвараас сэргийлэх арга хэмжээ, халдвартай үйлчлүүлэгчийг тусгаарлаж эмчлэх боломжийг бүрдүүлсэн байна
 - Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд шинж тэмдэгийн тандалт хийж халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг эрт тусгаарлах арга хэмжээг авч ажиллана.
 - Эмчлүүлэгч, эмнэлгийн мэргэжилтэнд халдвар илрүүлэх шинж тэмдэгийн

тандалтыг тасаг, нэгжийн халдварын сэргийлэлт, хяналтын ажилтан- ахлах сувилагч хийж, тасгийн эрхлэгч, тархвар судлаачид тогтмол мэдээлж ажиллана.

- Эмчлүүлэгчийг тусгаарлан тусгаарлан эмчлэх шаардлагатай үед эрүүл мэндийн сайдын 2019 оны А537 тоот тушаалыг баримтлан ажиллана.
- Хэвтэн эмчлүүлэх өрөөнд агаар сэлгэлтийн хуваарийг гарган мөрдөж ажиллах ба туслах сувилагч биечлэн хариуцна.
- Томуу, томуу төст өвчин болон бусад халдварын дэгдэлтийн үед үйлчлүүлэгчийг өрөөнөөс гаргахгүй тариа хийх, утлага, шарлага гэх мэт эмчилгээг аль болох өрөөнд хийх боломжийг бүрдүүлэх ба зайлшгүй шаардлагаар өрөөнөөс гарч эмчилгээ, оношлогоо хийлгэх бол тухайн газарт мэдэгдэж олон хүнтэй хавьтал болохоос сэргийлнэ. Эмчлүүлэгчид амны хаалт зүүлгэнэ.
- Олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай үед хавьтлын сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Тусгаарлалтын үед тусгаарласан өрөөний гадна талд анхааруулах тэмдэглэгээ хэрэглэнэ. Дараах тэмдэглэгээг эмчлүүлэгчийн өрөөний гадна байрлуулна:

-Улаан – олон эмэнд дасалтай нян / хавсралт -3 /

-В, С вирустай эмчлүүлэгчийг таних тэмдэг /хавсралт -4/

8.7.5 Тусгаарлалтын үед үйлчлүүлэгч, асран хамгаалагчид халдварын эсрэг дэглэмийг танилцуулан зөвөлгөө өгч, эргэлтийн цагийн хуваарийг чанд баримтлан, тасагт нэвтрүүлэхдээ хамгаалах хэрэгсэл өмсгөнө.

8.7.6 Түгээмэл ажилбарын үед хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Инвазив ажилбар хийгдэж байгаа бүх тохиолдолд асептик дүрмийг баримтална./төвийн венийн гуурс тавих, нугас , цээж, хэвлийн хөндий хатгах, гуурс тавих,зүслэг нээлт хийх/
 - Гарыг мэс заслын гар угаах техникийн дагуу зориулалтын сойзоор тохойноос ургаш угааж, халдваргүйтгэнэ.
 - Ариун хамгаалалт: халат, маск, малгай, ариун бээлий, ариун тусгаарлах хаалт хэрэглэнэ
 - 70%-ийн спирт, тамедин 0.7%,2,5%, 7,5%, хлоргексидины 2,5% уусмалын аль нэгээр арьсыг арчиж ажилбарын талбайг халдваргүйтгэнэ.
 - Ажилбарыг гүйцэтгэж буй хүн хурц үзүүртэй бүх зүйлийг аюулгүй хайрцагт хаяж хэвшсэн байна (зүү, хутганы ир зэрэг).
 - Бүх төрлийн гуурс тавьсан,мэс ажилбар хийсний дараа бүртгэж, хяналт, тандалтын хуудас хөтөлнө.
- 8.7.7 Ариун материалын хадгалалт хамгаалалт, хэрэглээ
- Хэвтүүлэн эмчлэх тасгууд нь ариун материал хадгалах зориулалтын шүүгээтэй байна.
 - Ариун материал тээвэрлэх явцад ариун байдлыг хамгаалах, цохих, бутлах, тахийлгах мурийлгах, унагаах гэмтэл гаргахаас сэргийлнэ.
 - Ариутгагдсан зүйл шалан дээр унахад ямар нэгэн гэмтэлгүй байсан ч бохирлогдсон гэж үзнэ
 - Зориулалтын савалгаа /рулон ууттай / боолттой, бүрэн бүтэн байдал алдагдаагүй, гадна тал бохирдоогүй, ариун материал нь хадгалах зориулалтын шүүгээнд хадгалсан бол ариутгасан багажийг 6 сар, бикстэй бол 72 цаг, рулон ууттай бол -14 , даавуун боолттой бол 7 хоног хадгална .

8.7.8. Эрүүл зүйн шинжилгээнд хамрагдах

Хэвтүүлэн эмчлэх тасагууд халдварын эрсдлийн үнэлгээнд үндэслэн орчны агаарын болон арчдасын шинжилгээг хувиарын дагуу хийлгэн тархвар судлаачийн дүгнэлт гарган шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

- Эмч эмнэлгийн мэргэжилтэн нян тээгч илрүүлэх шинжилгээнд хуваарийн дагуу хамрагдаж нян тээгчээр тогтоогдсон үед эмчилэн эрүүлжүүлэх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллана.

- ЭТҮХХ-ийн сэжигтэй тохиолдолд бүрт халдварын эрсдлийг тогтоох шинжилгээ, тандалт судалгааг зааврын дагуу хийж хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

8.7.9 Тасагт цэвэрлэгээ хийх

- Хэвтүүлэн эмчлэх тагууд нь ЭМСын 2019 оны 537 тоот тушаалын 6 дугаар хавсралт, цэвэрлэгээ үйлчилгээний журмын дагуу өдөр тутмын болон их цэвэрлэгээг хийж бүртгэл хөтлөж баримтжуулсан байна.

- Цэвэрлэгээний хяналтыг тасгийн ахлах сувилагч тогтмол хийж үйлчлэгчийг зааварчилгаа зөвөлгөө өгч ажиллана.

- Тасаг бүр цэвэрлэгээнд хэрэглэгдэх халдваргүйжүүлэх бодис найруулах боломжийг бүрдүүлсэн байна.

- Үйлчлэгч нь асаргасан цацагдсан биологийн шингэнийг халдваргүйжүүлэн цэвэрлэх болон цэвэрлэгээнд хэрэглэгдэх халваргүйжүүлэх бодисыг найруулах чадварыг бүрэн эзэмшсэн байна.

8.7.10 Хог хаягдлыг ангилан устгах

- ЭТҮ-ний үед үүссэн хог хаягдлыг ЭМС-ын 2017 оны 505 тоот тушаалын дагуу ангилан ялгаж түр хадгалах цэгт төвлөрүүлнэ.

8.8 ЖИЖҮҮРИЙН АХЛАХ ЭМЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.8.1 Өдөр бүрийн жижүүрийн ахлах эмчийг ЭЭДЗахирал томилно

8.8.2 Жижүүрийн ахлах эмч нь тухайн жижүүрийн багийн гишүүдийн үйл ажиллагааг хянаж удирдан жижүүрийн хугацаанд болсон үйл явдал хэрэг зөрчил, онцгой нөхцөл байдлыг эрх бүхий удирдах ажилтанд үнэн зөв тайлагнах мөн гэмт хэрэг хүчирхийлэлийн сэжигтэй гэмтэл, нас баралт, тохиолдлыг хариуцсан эмчийн хамтаар Цагдаагийн байгууллагат мэдэгдэх дуудлага өгөх үүрэгтэй.

8.8.3 Жижүүрийн ахлах эмч жижүүр эмч нарын тойрон үзлэгийг нэгээс доошгүй удаа удирдан хийж, шаардлагатай тохиолдолд жижүүр эмч нарын хамтарсан үзлэг зөвөлгөөнийг хийн хүнд хүндэвтэр өвчтний асуудлыг хамтран шийдвэрлэнэ.

8.11.1 Ажлын бус цагаар шаардлагатай ажилтныг зайлшгүй дуудах эсэхийг

жижүүрийн багийн эмч нартай зөвшилцөн шийдэж дуудагдсан тохиолдолд илүү цагийг баталгаажуулна.

8.11.2 Жижүүрийн хугацаанд эмнэлгийн барилга, сан техник цахилгаан галын

аюулгүй байдал эд аж ахуйн бүрэн бүтэн байдалд хяналт тавин хэрэг зөрчил гарах, хэвийн үйл ажиллагаа алдагдахаас сэргийлж ажиллана.

8.11.3 Гоц халдварт өвчин хоолны хордлого зэргийн сэжигтэй тохиолдол

илэрсэн тохиолдолд ЭЭДЗахирал ЭТҮЧАБА даргад шуурхай мэдээлэн хариу арга хэмжээ авна.

8.11.4 Жижүүрийн нэгдсэн мэдээг нэгтгэн өглөө бүр 08.00-09.30 цагт

ЭЭДЗахирал, ЭТҮЧАБА даргад цахимаар болон биечлэн тайлагнана.

8.9 ЖИЖҮҮР ЭМЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- **Хэвтүүлэн эмчлэх тасаг нэгжийн жижүүр эмчийн үйл ажиллагаа:**

8.9.1 Жижүүр эмч нарын хуваарийг тасгийн эрхлэгч нар сар бүр гаргаж ЭЭДЗахирал нэгтгэн хянаж БОЭТөвийн захирлаар батлуулна.

8.9.2 Эмнэлзүйн нөхцөл байдал, ачааллаас хамаарч жижүүрийн эгнээг нэмэх нэгтгэх, бууруулах зэрэг зохицуулалтыг ЭЭДЗахирал шийдвэрлэнэ.

Сар бүрийн жижүүрийн хуваарь болон ажил үүргийн хуваарь нь энэхүү журмын салшгүй хэсэг болно.

8.9.3 Жижүүрийн эмч нь жижүүрийн хугацаанд тухайн тасгийн өвчтний оношилгоо эмчилгээний асуудлыг бүрэн хариуцна./ Онош тодруулах, тойрон үзлэг хийх, хамарсан үзлэг зөвөлгөөн хийлгэх саналыг гарган ахлах эмчид мэдэгдэн шийдвэрлүүлэх/

8.9.4 Өндөр хяналтат эмчлүүлэгчийн биеийн байдлыг 3-4 цаг тутам дүгнэн шийдвэрлэж ажиллана. Шаардлагатай тохиолдолд эмчлүүлэгчийн эмчлэгч эмчтэй зөвшилцөнө.

8.9.5 Цэнхэр код журмын дагуу идэвхижиж журамд заасан үүргийг бүрэн биелүүлнэ. Утас, радио станцын бэлэн байдалыг хангаж ажиллана.

8.9.6 Эрэмбэлэн ангилалтын хэсэгт дуудагдан өвчтөнг үзэж эрэмбэлэн хэвтүүлэх талаар шийдвэр гаргаж, хариуцсан тасагт хэвтсэн эмчлүүлэгчийн өвчний түүхийг нээн онош эмчилгээг шийднэ.

8.9.7 Олон хоногоор үргэлжилсэн баяр ёслолын өдрүүдэд тасгаас эмчлүүлэгчийг гаргах асуудлыг эмчлүүлэгчийн эмнэлзүйн байдалд тулгуурлан шийднэ.

8.9.8 Мөн жижүүрийн хугацаанд тасгийн халдвар хамгаалал эмчилгээ үйчилгээнд хяналт тавин сувилагч туслах сувилагчийг арга зүйгээр хангана.

8.9.9 Шаардлагатай тохиолдолд нэмэлт эмч, мэргэжилтэн дуудах саналыг ахлахад тавиж шийдүүлж болох ба өөрөө болон жижүүрийн багаа шийдвэрлэх боломжтой эмнэлзүйн асуудлаар нэмэлт эмч мэргэжилтэн дуудахыг хатуу хориглоно.

8.9.10 Жижүүрийн цагаар өөрийн назологийн чиглэлээр эмчлүүлэгчийг тасагт хэвтүүлэх шийдвэр гарган авсан бол уг эмчлүүлэгчийн эмчлэгч эмчээр тухайн жижүүрийн эмчийг, амралтын өдрүүдэд эмнэлэгт хэвтэн хоног болоогүй нас барсан эмчлүүлэгчийн тохиолдолд хамгийн олон цаг эмчилсэн эмчийг эмчлэгч эмч гэж үзэх ба эмчлэгч эмчийн гүйцэтгэх үүргийг хариуцна./эмнэлгийн магадалгаа гаргах, түүх бичих, түүх хаах, эмгэг судлалын шинжилгээнд оруулах нас барсан тухай тодорхойлолт гаргах/

- **Оргүй хэсгийн жижүүр эмчийн үйл ажиллагаа :**

8.9.11 **Дуудлага хүлээн авагч эмч:** Утасны эхний 3 хонхоос хэтрүүлэхгүйгээр утсыг авч хариу өгөн дуудлагыг эрэмбэлэн ангилж анхан шатны баримт мэдээллийг бүртгэн баталгаажуулан эмч жолоочид мэдэгдэнэ.

8.9.12 Яаралтай тусламжийн шүүгээ, цүнхний орлого зарлагыг бэлэн байдлыг хариуцан цэнэглэнэ.

8.9.13 Эмнэлэг дээрх “CODE BLUE” тусламжийн багийг идэвхижүүлнэ.

8.9.14 Алсын дуудлагыг зохицуулах журмыг бүрэн хэрэгжүүлж заагдсан үүргийг чанд биелүүлнэ.

8.9.15 Төвийн **дуудлага гүйцэтгэгч эмч** дуудлагыг эрэмбийн дагуу гүйцэтгэн үзлэг эмчилгээ зөвөлгөө өгнө.

8.9.16 Холбогдох анхан шатны баримт бичгийг бүрэн бичиж баталгаажуулна. /дуудлагын хуудас, эмийн жор, зөвөлгөөг баталгаажуулна. Эргэх холбоо тогтоох боломжийг бүрдүүлж өгнө/

8.9.17 Эмнэлэг хүртэлх тусламжийн аюулгүй бэлэн байдлыг ханган хэрэгжүүлж ажиллана. Шаардлагатай тохиолдолд жижүүрийн багаас нэмэлт тусламж дуудах, өвчтөнг хүлээн авах, тусламж үзүүлэхтэй холбоотой нэмэлт бэлэн байдлыг хангуулах талаар холбогдох мэргэжилтэн эмч нарт мэдээлэл хүргэнэ. Жишээлбэл: дээрх “CODE BLUE” идэвхижүүлэх, машины төрөлтийн үед төрөх баг идэвхижүүлэх, мэргэжлийн эмч бэлэн байлгах гэх мэт

8.9.18 **Эрэмбэлэн ангилалт яаралтай тусламжийн эмч нь:**

Эмчлүүлэгчийн эрэмбийн дагуу шаардлагатай тусламжийг бүрэн үзүүлж, нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх, зөвөлгөө авах хэвтүүлэн эмчлэх буцаах зэрэг үйлдлийг шийдэж баримжуулна.

8.9.19 Ажиглалт хяналт шаардлагатай эмчлүүлэгчид ажиглалтын хугацаанд эмчлэгч эмчээр ажиллана.

8.9.20 Жижүүр эмч нар энэхүү журмын ээлж хүлээлцэх хэсэгт заасан зааварчилгааны дагуу эмчлүүлэгчийг хүлээлцэж ажиллана.

8.9.21 Жижүүрийн мэдээг жижүүрийн ахлахад цахимаар илгээн нэгтгүүлэх ЭЭДЗ, ЭТҮЧАБА даргад мэдээг цахим болон биечлэн өглөө биеийн 08.00-09.30 өгнө.

8.10 ЗӨВЛӨХ ЭМЧИЙН ҮЗЛЭГ, ЗӨВӨЛГӨӨ

8.10.1 Өөрийн мэргэжилийн чиглэлээр хүнд хүндэвтэр, эмчилгээ оношилгооны асуудал төвөгтэй, бие даан шийдвэрлэх боломжгүй эмнэлзүйн тохиолдолд шаардлагатай шинжилгээг бүрдүүлэн зөвлөх эмчид үзүүлэн зөвөлгөө авах хүсэлтээ эмчлэгч эмч санаачлан түүхэнд тэмдэглэнэ.

8.10.2 Тасагт хэвтэн эмчлүүлж байгаа эмчлүүлэгчийг эхлээд тухайн тасгийг хариуцсан нарийн мэргэжлийн эмч үзэж зөвлөх эмчээс зөвөлгөө авах санал гаргана.

8.10.3 Эрчимт эмчилгээ, эх барихын эмнэлзүйн асуудлаар зөвлөх эмч нар, онцгой хүнд тохиолдолд зөвлөх багаар зөвөлгөө хийн асуудлыг шийднэ.

8.10.4 СЭМТөвөөс зөвөлгөө авах тохиолдолд зөвхөн зөвлөх эмч нар утас цахимаар холбогдон зөвөлгөө өгнө. Зөвлөх эмч эзгүй тохиолдолд тухайн нарийн мэргэжлийн зэрэгтэй эмч зөвөлгөө өгнө.

8.10.5 Хөдөлмөр магадлалын комиссийн хурлаар шинээр орж ХЧА тогтоолгох өвчтөнг тухайн мэргэжлийн чиглэлийн зөвлөх эмч заавал үзэж дүгнэлт гаргасан байна.

Зөвлөх эмч нарын эзгүйд тухайн тасгийн эрхлэгч эмч эсвэл ЭЭДЗахирлын үүрэгжүүлсэн эмч орлон ажиллана.

Эрчимт эмчилгээ, хүүхдийн эрчимт эмчилгээний тасгуудад биеийн байдал хүнд эмчлэгдэж байгаа эмчлүүлэгчийг **эмнэлэгээс гартал** тухайн назологийн зөвлөх эмч эсвэл тасгийн эрхлэгч эмч нар өдөр бүр үзэж үзлэгийг баталгаажуулан зөвөлгөө өгч ажиллана.

8.12 ЭМЧ НАРЫН ХАМТАРСАН ҮЗЛЭГ, ЗӨВӨЛГӨӨН

8.11.1 Хэвтэн эмчлүүлж байгаа хүнд хүндэвтэр ,онош тодорхойгүй эсвэл хавсарсан олон эмгэгтэй,нарийн мэргэжлийн эмч нарын тус тусдаа хийсэн үзлэг оношилгооны зөрөөтэй байдал бүхий өвчтний эмнэлзүйн асуудлыг шийдвэрлэх зорилгоор тухайн мэргэжлийн эмч нарын болон бусад мэргэжлийн, зөвлөх эмч нарын хамтарсан үзлэг хийнэ.

8.11.2 Эмч нарын хамтарсан үзлэг зөвөлгөөнийг олон мэргэжлийн эмчийг оролцуулан хийх бол тухайн тасгийн эрхлэгч,жижүүрийн хугацаанд жижүүрийн ахлах нар санал гарган ЭЭДЗахирал оролцох эмч нарыг дуудан үүрэгжүүлж зөвөлгөөнийг удирдана.

8.11.3 Эмч нар хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд ажлын цагаар 15 минут, ажлын бус цагт 1 цагийн дотор зөвөлгөөнд ирэх үүрэгтэй.

8.11.4 Эмчлэгч эмч зөвөлгөөнд шаардлагатай нэмэлт мэдээлэл шинжилгээ оношилгооны хариу, карт зэргийг нэгтгэн бэлтгэж танилцуулах үүрэгтэй.

